



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 10 сарын 19 өдөр

Дугаар А/361

Мөрөн сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3.1, 9.3.6, 9.3.7 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мөрөн сумын хог хаягдлын цэгийн орчимд үүссэн малын сэг зэмийг цэвэрлэх, зайлуулах, цаашид эмх замбараагүй хаяж, тээвэрүүлэхгүй байх ажлыг зохион байгуулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Д.Идэрмөнх (Мөрөн сумын Засаг даргын үүрэг гүйцэтгэгч)

Гишүүдэд:

Д.Түмэнбар	(Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын дарга, улсын ахлах байцаагч)
Д.Ганбат	(Онцгой байдлын газрын орлогч дарга, дэд хурандаа)
П.Мөнхжаргал	(Аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга)
С.Мөнх-Эрдэнэ	(Аймгийн Хот, тохижилт үйлчилгээний төвийн дарга)
Б.Даваасүрэн	(Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын улсын ахлах байцаагч, хэлтсийн дарга)
Л.Мөнхбаатар	(Аймгийн Цагдаагийн газрын Экологийн асуудал хариуцсан Эрүүгийн ахлах мөрдөгч, хошууч)
Х.Цэнд-Аюуш	(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн ахлах мэргэжилтэн)
Н.Наранбаатар	(Мөрөн сумын Мал эмнэлгийн улсын байцаагч)
З.Соёлмаа	(Мөрөн сумын Засаг даргын Тамгын газрын Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн)


Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга:

Б.Батдорж (Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын улсын байцаагч)

2. Малын сэг зэмийг цэвэрлэх, цаашид тухайн үүссэн нөхцөлийг гаргахгүй байх зохион байгуулалтын арга хэмжээг шуурхай авч ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Д.Идэрмөнх)-д даалгасугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газарт (П.Ариунбат)-т даалгасугай.

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН